



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Аудитын код: САГ-2018/24/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддрож
Утас: 261740 Цахим хаяг: tsegmidдорjd@audit.gov.mn

Гэрээт аудитор Э.Энхбаатар
Утас: 261740 Цахим хаяг: egii0225@yahoo.com

Гэрээт аудитор Н.Сүнжидмаа
Утас: 261740 Цахим хаяг: sunjee_8206@yahoo.com


Улаанбаатар хот



Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Агуулга

1	Аудитын хураангуй тайлан.....	2
2	Аудитын гэрчилгээ.....	5
3	Аудитын тайлан.....	7
3.1	Оршил.....	7
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	7
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	8
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
3.5	Дотоод аудит.....	9
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	11
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	12
3.9.1	Урьдчилж гарсан зардлын талаар.....	12
3.9.2	Зөрчилгүй санал дүгнэлт авсан байгууллагуудын талаар.....	12
3.9.3	Түүвэрт хамрагдсан байгууллагын талаар.....	13
3.9.4	Үндсэн хөрөнгийн талаар.....	13
3.9.5	Төсвийн тухай хуулийн талаар.....	14
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	14
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	14
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	15
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	15
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	15
3.16	Үр өгөөжийн тооцоолол.....	16
4	Менежментийн захидал.....	17
4.1	Урьдчилж гарсан зардлын талаар.....	18
4.2	Алдаа зөрчлийн талаар.....	19
4.3	Зардлын талаар.....	20
4.4	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн талаар.....	21
5	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	22
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	22
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	23
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	24
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	25
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	26
6	Зөрчлийн нэгтгэл.....	28
7	Албан шаардлага.....	29





**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1019
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_KhêreglYawsan_Bichig\2018\0425SAG8.Docx



Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG8.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3 Аудитын тайлан

3.1 Оршил

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Барилга, хот байгуулалтын яамны санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд тайлангийн талаар, мөнгөн хөрөнгийн талаар, урьдчилж гарсан зардлын талаар, харьяа байгууллагад илэрсэн алдаа зөрчлийн талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 05-наас 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж төсвийн



ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж, гэрээт аудитор Э.Энхбаатар, Н.Сүнжидмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Барилга, хот байгуулалтын сайд 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 03/1109 дугаар албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Барилга, хот байгуулалтын яамны эрхэм зорилго нь барилга, хот байгуулалт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын ая тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллаж байна. Үүнд


- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх;
- Салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Төрийн захиргаа, хүний нөөц, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тогтолцоог хэрэгжүүлэх, удирдлагаар хангах зэрэг болно.

Барилга, хот байгуулалтын сайд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Барилга, хот байгуулалтын яам тайлант хугацаанд төлөвлөж хэрэгжүүлсэн ажлаа дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 10 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Төлөвлөсөн зарим арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар нэгтгэн харуулав. Тухайлбал;

- Барилгын тухай хууль, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын биелэлт 100.0 хувь;
- Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээний ажлын биелэлт 100.0 хувь;
- Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам сүлжээний ажлын биелэлт 90.8 хувь;
- Шинээр барих болон шинэчлэх цэвэрлэх байгууламжийн тоо ажлын биелэлт 60.0 хувь;
- Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох /хамрагдах аймаг, сумын төв, суурингийн тоо/ ажлын биелэлт 100.0 хувь;
- Газрын кадастрын мэдээллийн санг геодезийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх /хамрагдах аймаг, сумын төв, суурингийн тоо/ ажлын биелэлт 100.0 хувь;



- Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх ажлын биелэлт 104.0 хувь.

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан болно.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Барилга, хот байгуулалтын яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 12 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2015 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн сайдын 341 дүгээр тушаалтай нийцэхгүй болсон тул уг баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах талаар менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлсэн.


Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн багцад гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “сул” гэж үзлээ.



Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Барилга, хот байгуулалтын яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Тус газар “Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл түүний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах” гэсэн стратеги зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Хүснэгт №1: Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	7	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	6	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	6	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	45
		Дүн (сая.төг)	-
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	45
		Дүн (сая.төг)	-
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	-
		Дүн (сая.төг)	-

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын 2017 оны тайлан

Шилэн данс бүрэн хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, мөнгөн хөрөнгө, бараа материалын бүртгэлийн алдаа зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн бөгөөд тухай бүр зөвлөмж өгч ажиллажээ.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудитыг цаг тухайд нь хийж зөрчил дахин гаргахгүй байх тал дээр анхаарч ажилласны дүнд өмнөх зөвлөмжийн биелэлт 5.9 хувиар өссөн байна.


3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2017 онд хэрэгжүүлэх 10 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагуудын төвлөрүүлэх орлогын хэмжээг 1,765.2 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 1,831.5 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Гадаад тусламжийн орлогоос санхүүжих төлөвлөгөөг 819.4 сая төгрөгөөр баталсан боловч санхүүжилт хийгдээгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 110,496.7 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 14,279.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 74,525.1 сая төгрөг, гадаад төслийн зээлээс санхүүжих 21,691.9 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэлд нийт 79,931.1 сая төгрөг зарцуулж, төсөвт 80,565.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Урсгал зардалд 13,387.1 сая төгрөг зарцуулж, баталдсан төсвийн



892.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалд 66,544.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 7,981.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар зардал хэтрээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэн бэлтгэж гаргаагүй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Барилга, хот байгуулалтын сайд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Барилга, хот байгуулалтын яам өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт;
2. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт ;
3. Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл;
4. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл;
5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
6. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт
7. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.


“Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл” нь тайлант онд “shilendans.gov.mn” цахим хуудсанд нийт 107 мэдээлэл оруулахаас 68 мэдээлэл хугацаанд нь байршуулж 39 мэдээлэл хугацаа хоцорч байршуулсан буюу 63.5 хувьтай байна.

“Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл” нь тайлант онд “shilendans.gov.mn” цахим хуудсанд нийт 107 мэдээлэл оруулахаас 52 мэдээлэл хугацаанд нь байршуулж 55 мэдээлэл хугацаа хоцорч байршуулсан буюу 48.6 хувьтай байна.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Барилга, хот байгуулалтын яамтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.



Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад Төсвийн ерөнхийлөн захирагчийн мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өглөө.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний нийт 16 байгууллагын тайлан хамрагдсан байна.

Энэхүү санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан 10 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, 4 байгууллага аудитын түүвэрт, 1 байгууллага аудитад хамрагдаагүй буюу Нэгдсэн үндэсний байгууллагаас аудит хийдэг байна.

3.9.1 Урьдчилж гарсан зардлын талаар

Техник хяналтын данснаас урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 27.0 сая төгрөгийн холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасныг тус тус мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх

3.9.2 Зөрчилгүй санал дүгнэлт авсан байгууллагуудын талаар

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан 8 байгууллагад 219,300.5 сая төгрөгийн 30 алдаа зөрчил аудитаар илэрсэн байна. Аудитаар 218,429.4 сая төгрөгийн 9 албан шаардлага, 796.1 сая төгрөгийн 19 зөвлөмж өгч, 75.0 сая төгрөгийн 2 залруулга хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах, Төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.



3.9.3 Түүвэрт хамрагдсан байгууллагын талаар

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл:

1. Нийт 9.7 сая төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлогод аваагүй шууд зардлаар бүртгэсэн байна.
2. Цалингийн зардал 20.4 сая, байрны түрээсийн зардал 6.5 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Энэ нь Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2а-д “Бүх шатны төсвийн захирагч нарт салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зэргээр орон тоо, цалин хөлс, урсгал зардлыг бууруулах, батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх эрхийг олгох”, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолыг баримталж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3. “Түмэн наяд хайрхан” ХХК-тай 2016 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаартай 1 жилийн /2016.6.01-2017.6.01/ хугацаатай нийт 300 м2 талбайг 7.5 сая төгрөгөөр байр түрээслэх гэрээ байгуулсан байна. Тайлант 2017 онд нийт 45.0 сая төгрөг шилжүүлсэн боловч уг гэрээг дүгнэсэн акт протокол үйлдээгүй байна.
4. “Эмон” ХХК-тай 2017 оны 6 дугаар сарын 13-ний өдрийн 17/21 дугаартай 1 жилийн /2017.6.13-2018.6.13/ хугацаатай нийт 210 м2 талбайг 3.2 сая төгрөгөөр байр түрээслэх гэрээ байгуулсан байна. Тайлант 2017 оны 10 дугаар сараас эхлэн 4 сарын төлбөр болох нийт 12.6 сая төгрөгийг шилжүүлж үлдсэн 2 сарын төлбөр болох 6.3 сая төгрөгийг тайланд өглөгөөр тусгаагүй байна.


Шийдвэрлэсэн нь: Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслэх хугацаа, төлбөрийн нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгаж байх шаардлагатай байна. Гэрээний дагуу санхүүжүүлсэн эсэхийг тодорхой болгож, цаашид аливаа гэрээг дүгнэж акт протокол үйлдэж байх талаар албан шаардлага тогтоох.

3.9.4 Үндсэн хөрөнгийн талаар

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,138.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 567 дугаар тогтоолоор Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ нь дээрх үндсэн хөрөнгийг хүлээлцсэн актгүйгээр балансаас шууд хассан байна. Энэ нь уг тогтоолын 2.1-д “Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Дээрх алдаа зөрчлийн улмаас “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын аудит хийгдсэн санхүүгийн тайлан Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд 845.7 сая төгрөгийн зөрүүтэйгээр тусгагдсан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 567 дугаар тогтоолын 2.1 дэх “Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн оршин байх



эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 567 дугаар тогтоол, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг тус тус мөрдөж ажиллах талаар албан шаардлага тогтоох.

3.9.5 Төсвийн тухай хуулийн талаар

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-д “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр” гэж заасны дагуу бэлтгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх,

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын талаар

- Засгийн газрын 2016 оны 60, 2017 оны 48 дугаар тогтоолын дагуу Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолборыг санхүүжүүлсэн асуудлыг тодруулах;
- Дээрх тогтоолоос үүдэн “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын санхүүгийн тайланд нийт 24,730.5 сая төгрөгийн авлага, 19,836.5 сая төгрөгийн богино хугацаат өглөг, 2,130.9 сая төгрөгийн татварын өглөг бүртгэлтэй байна.
- Засгийн газрын 2016 оны 60 дугаар тогтоолын дагуу Төрийн банкаар дамжуулан аккредитив нээн, төлбөр хүүгийн зардалд нийт 2,565.1 сая төгрөгийг шилжүүлсэн байгаа нь “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын үйл ажиллагаатай холбоогүй зардал гарсан байна.

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын талаар

- Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 215, 216 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор “Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай” шийдвэр гарсан байна.
- “Монголын барилгын үндэсний ассоциаци”, “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулж, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх чиг үүргийг гүйцэтгүүлэх шийдвэр гаргасан байна.
- Дээрх асуудалтай холбоотой Засгийн газрын тогтоол болон Барилга, хот байгуулалтын сайдын тушаал, тус ТӨҮГ-ын зорилтот түвшинг баталсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолын эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хянах;

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 222,348.6 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3,048.1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн ба 2,984.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 63.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 2 зөвлөмж хүргүүлээ.

Нэгтгэлд хамрагдсан харьяа 8 байгууллага, аж ахуйн нэгж, төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 219,300.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс аудитаар 75.0 сая төгрөгийн 2 алдааг залруулж, санхүүгийн тайланг засуулснаас гадна 218,429.4 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага өгч, 796.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 19 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд Барилга, хот байгуулалтын яамны Хяналт – шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж ажилласан бөгөөд зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 90.9 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 03/3529 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн болно.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.


Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 112,220.7 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь буюу 2,244.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

Төлөвлөлтийн үе шатанд 2017 оны батлагдсан төсвийн нийт зарлагын дүнгийн 2 хувиар буюу 2,209.9 сая төгрөгөөр тогтоосон ба гүйцэтгэлийн үе шатанд тодорхойлсон материаллаг байдлын түвшингээс 34.5 сая төгрөг буюу 1.6 хувийн хэлбэлзэлтэй байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, үзвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг



зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааварын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 3,048.1 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Барилга, хот байгуулалтын яамны Санхүүгийн хэлтсийн болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 Урьдчилж ГАРСАН ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Техник хяналтын данснаас урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 27.0 сая төгрөгийн холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасныг тус тус мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Алдаа зөрчлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн тайланд хамрагдсан “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан нэр бүхий 8 байгууллагад 219,300.5 сая төгрөгийн 30 алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 218,429.4 сая төгрөгийн 9 албан шаардлага, 796.1 сая төгрөгийн 19 зөвлөмж, 75 сая төгрөгийн 2 залруулга хийсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах, Төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчих, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.



4.3 ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл:

- Нийт 9.7 сая төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлогод аваагүй шууд зардлаар бүртгэсэн байна.
- Цалингийн зардал 20.4 сая төгрөг, байрны түрээсийн зардал 6.5 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Энэ нь Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2а-д “Бүх шатны төсвийн захирагч нарт салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зэргээр орон тоо, цалин хөлс, урсгал зардлыг бууруулах, батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх эрхийг олгох”, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчих, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах.

ҮАГ-ын зөвлөмж

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах, Төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**4.4 Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн
ТАЛААР**

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-д “Тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/” гэж заасны дагуу бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-д “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасныг мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчих, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/МЯН.ТӨГ/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	518,755,085.9	473,955,868.0
МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,826,185.1	27,567,021.3
АВЛАГА	149,756,990.3	134,977,930.5
УРЬДЧИЛГАА	34,106,247.2	3,080,878.0
БАРАА МАТЕРИАЛ	58,992,742.6	61,401,688.6
НӨӨЦИЙН БАРАА	25.7	25.7
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	260,072,895.0	246,928,323.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	324,449,481.5	351,291,840.4
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,000.0	1,000.0
Урт хугацаат зээл	1,000.0	1,000.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	324,448,481.5	351,290,840.4
Биет хөрөнгө	323,658,669.9	350,208,292.8
Биет бус хөрөнгө	116,003.1	152,488.4
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	673,808.5	930,059.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	843,204,567.5	825,247,708.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР	384,755,795.4	396,899,835.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	70,819,718.9	97,972,931.0
Өглөг	41,226,147.3	67,279,728.0
Урьдчилж орсон орлого	29,593,571.6	30,693,203.0
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	313,936,076.5	298,926,904.9
Урт хугацаат зээл	313,936,076.5	298,926,904.9
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	458,448,772.1	428,347,872.5
Засгийн газрын хувь оролцоо	458,448,772.1	428,347,872.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,478,158.8	2,478,158.8
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	8,247.3	8,247.3
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	307,592.9	307,592.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	5,594,406.0	5,553,814.7
Хуримтлагдсан үр дүн	450,012,523.6	419,952,215.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,843.5	47,843.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	843,204,567.5	825,247,708.4

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

5.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	172,048,790.6	170,880,324.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,191,259.9	45,946,008.9
Нийтлэг татварын бус орлого	48,804,073.9	45,946,008.9
Тусламжийн орлого	387,186.0	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	122,857,530.7	124,934,315.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	126,263,545.0	112,220,707.6
УРСГАЛ ЗАРДАЛ	126,263,545.0	112,215,635.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,479,374.4	102,592,044.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,651,261.3	3,095,211.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	294,112.4	333,558.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,603.3	272,475.9
Хангамж, бараа материалын зардал	50,681,718.2	66,884,781.4
Нормативт зардал	132.0	904.0
Эд хогшил, урсгал засварын зардал	33,617.2	42,094.1
Томилолт, зочны зардал	39,481.7	85,057.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,253,463.8	30,406,866.2
Бараа үйлчилгээний бусад зардал	1,277,984.7	1,471,095.6
ХҮҮ	5,121.4	7,260.2
ТАТААС	-	6,040.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,779,049.2	9,610,290.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,072.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	45,785,245.6	58,659,617.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	23,110,570.4	67,627.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,763,842.4	3,032,261.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	50,131,973.6	55,694,983.1

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	318,587,253.0	-	318,587,253.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	90,151,756.3	-	90,151,756.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408,739,009.3	-	408,739,009.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	13,921.8	-	13,921.8
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-436,132.6	-	-436,132.6
Тайлант үеийн үр дүн	50,131,973.6	-	50,131,973.6
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	458,448,772.1	-	458,448,772.1
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	458,448,772.1	-	458,448,772.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-85,720,205.8	-	-85,720,205.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	372,728,566.3	-	372,728,566.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-91,456.8	-	-91,456.8
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	15,779.9	-	15,779.9
Тайлант үеийн үр дүн	55,694,983.1	-	55,694,983.1
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	428,347,872.5	-	428,347,872.5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	204,437,585.1	158,319,938.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,547,092.6	77,561,613.9
Нийтлэг татварын бус орлого	97,159,906.6	77,561,613.9
Тусламжийн орлого	387,186.0	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,890,492.4	80,758,324.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,397,362.6	33,666,097.4
УРСГАЛ ЗАРДАЛ	65,397,362.6	33,666,097.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,689,059.1	23,925,415.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,147,711.7	5,968,368.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,340,676.8	1,303,952.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	695,162.9	279,763.4
Хангамж, бараа материалын зардал	39,346,401.1	7,019,521.4
Нормативт зардал	140.0	1,538.9
Эд хогшил, урсгал засварын зардал	62,865.3	27,983.4
Томилолт, зочны зардал	58,391.1	144,823.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,395,109.9	5,114,319.6
Бараа үйлчилгээний бусад зардал	2,642,600.3	4,065,143.9
ТАТААС	-	6,040.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,708,303.5	9,734,642.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	139,040,222.5	124,653,840.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	160,420.5	298,529.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	99,228,082.2	67,202,366.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	99,228,082.2	67,202,366.7
Дотоод эх үүсвэрээр	99,228,082.2	67,202,366.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-99,067,661.7	-66,903,836.9
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-38,666,951.0	-46,009,167.6
Бусад эх үүсвэр	1,903,356.4	3,623,480.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,215.0	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	40,567,092.4	49,632,648.4
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,305,609.8	11,740,836.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,520,575.3	15,826,185.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,826,185.1	27,567,021.3

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ


Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	110,496,731.6	79,931,075.5	30,565,656.1	72.3
УРСГАЛ ЗАРДАЛ	14,279,683.7	13,387,047.0	892,636.7	93.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,718,690.0	5,855,177.0	863,513.0	87.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,422,243.5	2,415,279.3	6,964.3	99.7
Үндсэн цалин	1,740,154.7	1,732,929.8	7,224.9	99.6
Нэмэгдэл	499,734.1	499,734.1	0	100
Унаа хоолны хөнгөлөлт	109,734.1	109,994.7	-260.6	100.2
Гэрээт ажлын хөлс	72,620.6	72,620.6	-	100
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	266,446.6	266,022.7	423.9	99.8
Тэтгэврийн даатгал	169,557.0	169,287.2	269.8	99.8
Тэтгэмжийн даатгал	23,891.0	23,860.1	30.9	99.9
ҮОМШӨ-ний даатгал	19,709.3	19,670.8	38.5	99.8
Ажилгүйдлийн даатгал	4,844.4	4,836.7	7.7	99.8
Эрүүл мэндийн даатгал	48,444.9	48,367.8	77.1	99.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	177,991.7	132,710.4	45,281.3	74.6
Гэрэл, цахилгаан	120.0	117.1	2.9	97.6
Түлш, халаалт	837.0	739.9	97.0	88.4
Цэвэр, бохир ус	480.0	463.9	16.2	96.6
Байрны түрээс	176,554.7	131,389.4	45,165.3	74.4
Хангамж, бараа материалын зардал	196,281.9	144,707.1	51,574.8	73.7
Бичиг хэрэг	41,243.1	35,063.6	6,179.5	85.0
Тээвэр, шатахуун	80,492.4	50,665.1	29,827.4	62.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,022.3	27,746.2	9,276.1	74.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	199.1	-	199.1	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,325.0	31,232.1	6,092.9	83.7
Нормативт зардал	633.6	627.1	6.5	99.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	633.6	627.1	6.5	99.0
Эд хогшил, урсгал засварын зардал	12,449.0	12,448.1	0.9	99.9
Багаж, техник, хэрэгсэл	2,153.0	2,854.8	-701.8	132.6
Урсгал засвар	10,296.0	9,593.3	702.7	93.2
Томиллолт, зочны зардал	35,239.5	34,563.5	676.0	98.1
Дотоод албан томилолт	35,239.5	34,563.5	676.0	98.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,363,935.1	2,659,625.0	704,310.1	79.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,081,619.6	2,378,898.7	702,720.9	77.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990.0	294.4	695.6	29.7
Даатгалын үйлчилгээ	8,541.3	7,884.6	656.7	92.3
Тээврийн хэрэгслийн татвар	1,151.8	978.0	173.8	84.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	693.0	638.0	56.0	92.1



Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,245.0	25,242.0	3.0	99.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	245,694.4	245,694.3	0.1	100
Бараа үйлчилгээний бусад зардал	243,469.1	189,193.9	54,275.2	77.7
Бараа үйлчилгээний бусад зардал	243,469.1	189,193.9	54,275.2	77.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,560,993.7	7,531,870.1	29,123.6	99.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,321,303.6	7,295,856.9	25,446.8	99.7
Засгийн газрын дотоод шилжүүлэг	7,319,392.5	7,293,950.8	25,441.7	99.6
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,911.1	1,906.0	5.1	99.7
Бусад урсгал шилжүүлэг	239,690.1	236,013.2	3,676.9	98.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	143,220.8	143,143.9	76.9	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,769.3	57,769.3	-	100
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,700.0	35,100.0	3,600.0	90.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	74,525,117.0	66,544,028.5	7,981,088.5	89.3
Барилга байгууламж	74,397,991.4	66,493,124.8	7,904,866.6	89.4
Тоног төхөөрөмж	127,125.6	50,903.7	76,221.9	40.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	21,691,930.9	-	21,691,930.9	-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	21,691,930.9	-	21,691,930.9	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	110,496,731.6	80,870,758.6	29,625,973.0	73.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	86,017,590.4	78,267,079.0	7,750,511.4	91.0
Улсын төсвөөс санхүүжих	86,017,590.4	78,267,079.0	7,750,511.4	91.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	23,659,700.1	2,603,679.6	21,056,020.5	-
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	23,659,700.1	2,603,679.6	21,056,020.5	-
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	819,441.1	-	819,441.1	-
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	819,441.1	-	819,441.1	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	11,199,188.8	-11,199,188.8	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	15,215,040.5	-15,215,040.5	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	-
Төсвийн байгууллага	2	2	-	-
Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	160	160	-	-
Удирдах ажилтан	15	15	-	-
Гүйцэтгэх ажилтан	120	120	-	-
Үйлчлэх ажилтан	-	-	-	-
Гэрээт ажилтан	17	17	-	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**